



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/298

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын үйл ажиллагаа, холбогдох хууль журмыг шторк, видео хэлбэрээр орон нутгийн телевиз, цахим сайтаар иргэдэд сурталчлах, олон нийтэд хүргэх мэдээллийн зардалд зориулж 600.000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 600.000 төгрөг /зургаан зуун мянга/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 5.22 дахь заалт “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах” хөтөлбөрөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ